

“Суурь боловсролын үндэсний үнэлгээ” төсөл

Төслийн тайлбар

Энэхүү төсөл нь ЕБС-д эзэмшиж байгаа суурь боловсролын сурлагын амжилтыг үнэлэх үндэсний хэмжээний судалгаа бөгөөд 2010-2011 оны хичээлийн жилд хэрэгжинэ.

Төслийн хэрэгцээ

Боловсролын чанарт үнэлгээ хийн хэмжих асуудал нь боловсролын салбарын бодлого боловсруулагчдын өмнө тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд суурь боловсролын стандартуудын гол агуулга нь суралцагчдад **цогц чадамж эзэмшүүлэх арга зүй** боловч уламжлалт сургалтын арга зүйгээр сурагчдад цээж мэдлэг дамжуулдаг арга зүй багш нарын хувьд давамгайлдаг нь олон шалтгаантай. Тиймээс сурлагын амжилтанд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлүүд болон сургалтын явцад хүүхэд юу сурч байгаа талаарх мэдээллийг үнэн зөв үнэлэхийн зэрэгцээ сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох шаардлага урган гарсаар байна.

БҮТ нь 2007-2008 онд “Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл”-ийн хүрээнд Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээг хийсэн бөгөөд үндэсний хэмжээний туршлага, сургамж авсан үйл ажиллагаа болсон билээ. Үүнтэй уялдан юун түрүү суурь боловсролын чанарын үнэлгээг хийх хэрэгцээ урган гарч ирж байгаа юм. Энэхүү үнэлгээний үр дүнг БСШУЯ болон бодлого боловсруулагчид, судлаачид, сургууль, багш нар ашиглах бүрэн боломжтой болно. Түүнчлэн аймаг, нийслэл (сум, дүүрэг, хороо)-ийн сургуулиудын сургалтын ерөнхий төвшин тодорхой болж, өөрсдийн сургалтын агуулга, аргазүйдээ үнэлгээ өгч, түүний ул мөрөөр тодорхой үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.

Төслийн зорилго, зорилт

Суурь боловсролын физик, хими, биологи, газарзүйн хичээлийн стандартын агуулга, хэрэгжилтийг дүгнэх, уг түвшинд суралцагчдийн салангид эзэмшиж байсан мэдлэг, чадваруудыг нэгдмэл байдлаар олон улсын аргачлалаар үнэлэх, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багш нарын бүрэлдэхүүн, хангамж, чадвар зэргийг судлахад оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн тавьж байна.

Үүнд:

- Суурь боловсролын төгсөх ангийн суралцагчдын байгалийн ухааны хичээлүүдээр олж авсан мэдлэг, чадварыг нэгдмэл байдлаар үнэлэх үнэлгээний аргачлал боловсруулах
- Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах
- Суурь боловсролын байгалийн ухааны хичээлүүдийн стандартад нийцсэн даалгаврын сан бүрдүүлэх, үнэлэх
- Байгалийн ухааны хичээлүүдэд хандах хандлага болон нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
- Суурь боловсролын байгалийн ухааны үндэсний үнэлгээний тайлан, сурлагын амжилтын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулан гаргах